

МОНГОЛЫН ХОШИН, ШОГ НИЙТЛЭЛИЙН ҮНДСЭН СЭДВҮҮД

Н.Мөнхзориг*

* "Идэр" дээд сургууль, Монгол хэл, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, магистр, докторант

Түлхүүр үг: шог хошин нийтлэл, "Хүмүүжил жигшил" сэтгүүл, "Матар" сэтгүүл, "Тоншуул" сэтгүүл, хошин шог нийтлэлийн үндсэн сэдвүүд, бичлэгийн төрөл зүйл.

Монголын хошин шог нийтлэлд тусгагдаж ирсэн сэдвүүдийн тухай ярихад 1935 оны 11-р сард анхны дугаар нь хэвлэгдэн гарсан нийгэм-улс төрийн шог сэтгүүл «Хүмүүжил ба жигшил», 1942 оны 1-р сард анхны дугаар нь гарсан «Матар» сэтгүүл («Хүмүүжил ба жигшил»-ийн үргэлжлэл), мөн 1961 оны 1-р сараас 1965 он дуустал эргээд хуучин нэрээрээ гарч эхэлсэн «Хүмүүжил жигшил» (ба холбох үггүйгээр) сэтгүүлүүдийн нийтлэлийг авч үзэх нь зүй. Учир нь энэ үеэс л манай хошин шог нийтлэл төлөвшиж эхэлсэн байдаг.

1942-оос 1960 он хүртэл хэвлэгдсэн «Матар» сэтгүүлд дараах сэдэв тусгагдаж байв. Энэ нь:

- албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтан;
- Гитлер тэргүүтэй харгис хэрцгий фашизм;
- ардын сургуулийн шинэ үсгийн багш, сурагчид;

- архичид, тамхичид;
- хулгайчид;
- муу малчид;
- харгис этгээдүүд;
- завшигчид, залилан мэхлэгчид, луйварчид;
- хөдөлмөрийн шинэ хүний төөрөгдөл, шинэ цагийн хөгжилд саад бологчид;
- бохир заваан байдал;
- хариуцлагагүй эмч нар;
- завхай явдалтнууд;
- сонины уншлага таслагчдыг шоглосон нийтлэлүүд хэвлэгдэж байв. Ингэхдээ гэм дутагдалтай этгээдүүдийг хот, байгууллага, аймаг, сум, багийнх нь болон өөрийнх нь нэр усыг тодорхой заан ёгтлон шоглож байв.

«Матар» сэтгүүлийн нийтлэлүүдэд тусч байсан нэг чухал сэдэв бол цагийн байдлаас шалтгаалаад фашизмын харгис дэглэм, фашизмыг илт үзэн ядан шоглож байсан явдал мөн. Судлаач Г.Жамсранжав 1940-өөд оны шог хошин зохиолын нэг гол сэдэв нь Гитлерийн фашизм, Японы милитаризмын харгис хэрцгий шинжийг шог хурц үгээр илрүүлэн жигшүүлэхэд чиглэж байсныг онцолжээ. Тэр үед энэ сэдвээр Д.Даржаа, Ц.Цэдэнжав нарын зохиолчид шог үгс, шог яриа олныг бичсэн байдаг.

Д.Даржаа «Фашист офицер, цэрэг хоёрын яриа», «Хоёр цэргийн яриа», «Хариковын хөлсөнд», «Рапорт» зэрэг шог үгсээ фашистуудын үзэл санаа, ёс суртахуунгүй, хүний үнэргүй шинжийг элэглэн шоолж, шүүмжлэн жигшүүлсэн байна. «Хуучныг үзсэн хоёр» шог үгсдээ Монгол, Зөвлөлтийн дайчдын Халх гол дахь хамтын ялалт нь Японы самурай нарын зүрхэнд хүрч, сүр сүлдийг нь унагасныг шоолжээ. Иймэрхүү шог үгс, шог гараа, жижиг үзэгдлүүд нь фашист яргачдын зэрлэг балмад бузар муухай заль мэхийг илчилж, уншигч, үзэгч түмний сонор сэрэмжийг дээшлүүлэн, ялалтад итгэх итгэлийг бэхжүүлэхэд чиглэж байв.

Манай зохиолчид ялангуяа шог үгсийг хуульч Сандагийн шог үгс, бадарчны шог ярианы хэлбэрийг ашиглан Зөвлөлтийн зохиолчдын бичсэн шог ярианы жишээгээр бичиж байжээ. Хуульч Сандагийн шог үгс, бадарчны шог яриа нь шар, хар феодал, харийн худалдаачдын хар муу санаа, харгис бурангуй шинжийг уудлан илрүүлэх зэвсэг болж байсан бол дайны үед манай зохиолчдын бичсэн шог үгс, шог яриа, шог гараа, жижиг үзэгдлүүд фашист дайчдын хүн шинжээ алдсан байдал, араатан шинжийг илрүүлэн ниргэх зэвсэг болж байжээ.

«Матар» сэтгүүл гарч байсан он жилүүд бол шинэ цаг үе, хөдөлмөрийн шинэ хүн, түүний хүсэл тэмүүлэл, мөрөөдөл, бүтээн байгуулалт, амьдралын хэв маяг, ажил үйлс, ер нь олон шинэ зүйлийн эхлэлийн тун эмзэг хийгээд ээдрээтэй үе байсан юм. Тийм ч учир олон арван алдаа дутагдал «Матар» сэтгүүлийн уран бүтээлийн

хамт олны анхаарлын төвд байж, санаа сэтгэлийг зовоож байв.

Сэтгүүлийн нийтлэлийн өөр нэг гол сэдэв бол хөдөлмөрийн шинэ хүний төөрөгдөл, шинэ цагийн хөгжилд саад бологчид юм. Энэ сэдвээр бичигдсэн нийтлэлийн гол онцлог нь хөдөлмөрийн шинэ хүний гаргасан санамсаргүй алдаа, төөрөгдлийг тусгахаасаа илүүтэй тэд хичээл зүтгэл гаргаж хөдөлмөрлөхгүй байгааг шогложээ. «Матар» сэтгүүлд нийтлэгдсэн «Хэгжүүн зантай Гэндэндорж, хэтэрхий тасалдаг Дугаржав»¹ хэмээх өгүүлэлд сангийн яамны дэргэдэх эвлэлийн үүрийн гишүүн Гэндэндоржийн олон нийтийн субботникийг удаа дараалан тасалдаг, ов заль хэрэглэн оргож зайлахдаа онц мэргэний дээр учрыг олж сураглавал улам гөжиж уурсдаг төдийгүй, гишүүн ажилчдын захиалсан сониныг хүртэл сав шүүгээнд гэмтэж илжиртэл нь 3-4 сар дарж байхад нь өөр байгууллага олж илрүүлсэн зэргийг шоглон шүүмжлээд, «...гишүүн Гэндэндоржийн мэргэжиж сурсан нь хэгжүүн зангаар хэрүүл үүсгэх, хий суудлаар гэрэл сүйтгэх, унтаж уншлагаас хожимддог, уурсаж дугуйлангаа тасалдаг, хүнд суурьтайгаар хөдөлж, хөдөлмөрийн цагийг тасалдаг, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй, эвлэлийн үүртэй үнэлэлтгүй ийм залуу юм...» гэхчилэн илчилж бичихийн хамт дээд сургуулийн оюутан Дугаржав сонины уншлага тасалдаг явдлыг ч шүүмжлээд амжжээ.

Мөн «Матар» сэтгүүлд нийтлэгдсэн «Чанрав даргын чанар байдал»² хэмээх өгүүлэлд Дорнод аймгийн Очирбаянмөнх сумын дарга Чанравын хийж бүтээж байх ажил ч үгүй, хэдэрлэж хачин үг хэлээд, аймгаас гарсан тушаал тогтоо-

лыг арай чамай нэг харахдаа «За нэг ял ирлээ. Хөгшин толгой юу үзэж өгөх бол» гээд хойргошиж суусаар ноос хөөвөр цуглуулах хугацаатай ажлыг ноль тэгээр дүгнүүлж байгаа байдлыг шүүмжлээд, «...хөдөлмөрчин ардын оргилсныг хөг-

жилтэй сайхан хөдөлгөөнийг анхаарч огт хэрэгсэхгүй, амаа ангайж гөлрөгч чи хүнд суртлаа өөрчилж, хөнгөн шаламгай болж, амжилт бүтээлийг үзүүлэхгүй бол аргадаж чамайг хүлээхгүй шүү» гэж анхааруулжээ.

Хошин шог нийтлэлийн сэдвийн харьцуулсан хүснэгт

«Матар» сэтгүүлийн нийтлэлийн сэдэв	«Хүмүүжил жигшил» сэтгүүлийн нийтлэлийн сэдэв	«Тоншуул» сэтгүүлийн нийтлэлийн сэдэв
1. Албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтан	1. Албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтан	1. Албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтан
2. Гитлер тэргүүтэй харгис хэрцгий фашизм	2. Баяр цэнгэл хөөгчид болон олон баяр цэнгэл	2. Баяр цэнгэл хөөгчид болон олон баяр цэнгэл
3. Ардын сургуулийн шинэ үсгийн багш, сурагчид	3. Залхуучууд	3. Зурхайчид
4. Архичид, тамхичид	4. Хоосон цэцэрхэгчид	4. Архичид
5. Хулгайчид	5. Нийгмийн хөгжлөөс хоцрогчид	5. Хулгайчид
6. Муу малчид	6. Хүнд суртал	6. Боловсролын тогтолцоо
7. Харгис этгээдүүд	7. Гэр бүлийн хүчирхийлэгчид	7. Гэр бүлийн хүчирхийлэгчид
8. Завшигчид, залилан мэхлэгчид, луйварчид	8. Завшигчид, залилан мэхлэгчид, луйварчид	8. Хов жив хөөцөлдөгчид
9. Хөдөлмөрийн шинэ хүний төөрөгдөл, шинэ цагийн хөгжилд саад бологчид	9. Хүн чанараа алдагсад	9. Хүн чанараа алдагсад
10. Бохир заваан байдал		11. Мөнгөнд дулдуйдагчид
11. Хариуцлагагүй эмч нар		12. Цагдаа нар
12. Завхай явдалтнууд		13. Нийгмийн эмзэг бүлгийнхэн
		14. Байгаль эхээ сүйтгэгчид
		15. Ардчилал, хүний эрх, шударга ёсыг зөрчигчид
		16. Улс төрийн тогтолцооны согог
		17. Авлига авагсад
		18. Хэл ярианы соёл алдагдуулагчид
		19. Цэнгээний газрууд

«Хүмүүжил жигшил» сэтгүүл гарч байсан 1960-аад оны үед хошин шог нийтлэлийн сэдэв нь харьцангуй цөөн, тодруулбал 10-аад сэдвийн хүрээнд л эргэлдэж байсан нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Энэ ч бас учиртай болов уу. Учир нь 1930, 40, 50-иад оныг бодоход 1960-аад оны үе бол хуучин, шинэ хоёр цаг үеийн зөрчил тодорхой хэмжээгээр алга болж, хөдөлмөрийн шинэ хүн шинэ нийгэм, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах болсон, төлөвшиж, туршлагажчихсан үе байсан билээ.

Энэ ч учраас шоглож шүүмжлэх, ёгтолж хошигнох, дамшиглаж даапаалах, даваадуулж хэтрүүлэх, эерүүлэн элэглэх, үгчлэн доромжлох сэдэв харьцангуй цөөрч, нийгэм ч тэр хэмжээгээр эрүүлжсэн байж болох талтай. Үүнийг «Матар» сэтгүүлийн нийтлэлд идэвхтэй байр эзэлж байсан хөдөлмөрийн шинэ хүний төөрөгдөл, шинэ цагийн хөгжилд саад бологчид, ардын сургуулийн шинэ үсгийн багш, сурагчид зэрэг өмнөх үед түгээмэл байсан сэдэв алга болсноос харж болно.

1961 оны 1-р сараас 1965 оны 12-р сар хүртэл эргээд «Хүмүүжил жигшил» нэрээрээ гарч байсан энэ сэтгүүл албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтан; хөдөлмөр ажлаас зугтан баяр цэнгэл хөөгчид болон элдэв олон баяр цэнгэл; залхуучууд; хоосон цэцэрхэгчид; хөгжлөөс хоцрогчид; хүнд сурталтнууд; гэр бүлийн хүчирхийлэгчид; завшигчид, залилан мэхлэгчид, луйварчид; хүн чанараа алдагсдыг шоглож байжээ. Хөдөлмөрийн шинэ хүнийг төлөвшүүлэх асуудал онцгой тавигдаж байв. Ийм сэдвийн нэг нь хоосон цэцэрхэгчид юм. Д.Гомбосүрэнгийн «Хамхуул

шиг»³, Г.Жамьяандоржийн «Ерөнхий ажилтай ерөнхий механикч»⁴, Т.Бадарчийн «Цэцэн даргын гайгаар»⁵, Д.Намжилын «Мунахүү Мундраа хутгаж байна»⁶ зэрэг шог найруулал, Даг.Жамьяаны «Хоосон маргагчид» шог гараа⁷ гэх мэт олон нийтлэл энэ сэдвээр бичигджээ. Сэтгүүлийн 1963 оны 2 дахь дугаарт нийтлэгдсэн Г.Жамьяандоржийн «Ерөнхий ажилтай ерөнхий механикч» шог найруулалд Гачууртын сангийн аж ахуйн ерөнхий механикч Нямжав гэгч ирсэн өдрөөсөө эхлээд сангийн аж ахуйн бүхий л ажилд халуун амь, бүлээн цусаа хайрлахгүй зүтгэнэ гэж тангарагласан ёсоороо машин трактор засахыг доод хүмүүстээ ерөнхийлөн даалгаж, аж ахуйн ажил эмхлэн цэгцлэхэд ч идэвх зүтгэлтэй оролцон, сайшаал шагналын асуудлыг бараг ганцаараа гардан хариуцах болсныг шоглон шүүмжилсэн байдаг.

1960-аад онд хошин шог сэдвээр Даг.Жамьяан, Д.Баянбилэг, Н.Иштавхай, Б.Бааст, Н.Цэвэгмэд, Д.Гармаа, М.Гүрсэд, Л.Лодоншарав, Г.Жамьяандорж, Ч.Ойдов, Ё.Мийяа нар голлон бичиж байсан юм. Тэднээс Даг.Жамьяан, Н.Иштавхай, Б.Бааст, Н.Цэвэгмэд, Д.Гармаа, М.Гүрсэд, Л.Лодоншарав нарын хошин шог нийтлэл «Хүмүүжил жигшил»-ийн гол ноён нуруу болж байна.

1970, 1980-аад оны үеийн манай хошин шог нийтлэл нь ерөнхийдөө элэглэн шоглосон гэхээсээ илүүтэйгээр хошигнон егөөдсөн маягтай байв. Энэ нь аливаа гэм дутагдлыг шууд нэвт шувт шүүмжлэх аргагүй байсантай холбоотой болов уу. Тэр ч үүднээс энэ үеийн хошин шог нийтлэл нь дутагдал доголдлыг шүүмжлэхдээ аргацаасан, ил шууд биш,

далдуур хатгасан, егөөдсөн маягтай байсан нь ажиглагддаг. 1970, 1980-аад оны үед хариуцлагагүй дарга, хүн чанараа алдагсад, төлөвлөгөө таслалт, хуурамч хяналт шалгалт, хөрөнгөтний нийгмийн тогтолцоо, хоосон цэцэрхэгчид, хүнд суртал гэх мэт сэдвээр бичигдсэн нийтлэл давамгайлж байв. Ялангуяа хуурамч хяналт шалгалт, шинэ санаачилга гаргах гэж зүдрэгчдийг донжтой даапаалах болжээ. Хариуцлагагүй даргыг шүүмжлэх тухайд сумын дарга, бригадын даргаас дээш албан тушаалтныг шоглодоггүй байсныг онцолмоор байна. Дандаа доод албан тушаалын малын эмч, сумын дарга, бригадын дарга, зоо техникч зэрэг хүмүүсийг ёгтлон шоглодог, сумын даргаас дээш албан тушаалтныг бараг шоглодоггүй байжээ.

Харин 1990-ээд он гарч, шинэ нийгэм, шинэ эрин үе эхэлж, хүмүүсийн сэтгэлгээнд чөлөөтэй, өөрөөр, өөрийн дураар сэтгэх боломж бүрдсэнээр манай хошин шог нийтлэл тусгах сэдвийн хувьд нэлээд чөлөөтэй, хуучин хориотой байсан сэдвүүдийг хүртэл хөнддөг болсон төдийгүй тоо нь ч олширчээ. Ерээд он гарснаар мэргэжлийн шогч Шаг.Цэнд-Аюушийн «Далдын хар малгай», «Хүлээх өрөөний эзэгтэй» (1991) гэсэн манай утга зохиолд төдийлөн төлөвшөөгүй шог хошин романууд хүртэл хэвлэгдэж амьдралд бугшиж байсан хүнд суртал, ажлын шат дамжлага, хүний мөсгүй

муухай явдал зэрэг нийгэм улс төрийн тогтолцоо, хувь хүний нарийн төвөгтэй зөрчлийг үйл явдлын олон шугамаар нээн өрнүүлж, гол ба туслах хэд хэдэн баатрын хувь заяаг хэв шинжит дүрээр тэдний амьдрал тэмцлийн гол үеүдээр цомог маягтай хүүрнэн өгүүлж, дүрслэлийн олон янзын аргыг чадамгай хэрэглэж баатруудын санаа сэтгэлийн орчлон, хүрээлэн буй нөхцөл байдал зэргийг өргөн дэлгэр үзүүлснийг судлаач Ш.Гүндалай үнэлсэн байдаг.

1990 оноос хойшх үеийн хошин шог нийтлэлийн үндсэн сэдвүүдийг «Тоншуул» сэтгүүлийн нийтлэлийн жишээн дээр тулгуурлан гаргалаа. Улс төр, авлига, мөнгө, хэл ярианы соёл алдагдуулагчид, хүнд суртал, Монголоо алдагсад,

залхуурал, хоосон амлалт, архидалт, нийгмийн замбараагүйдэл, ядуурал, заль луйвар, гэмт хэрэг, зурхайчид зэрэг нь 1990 оноос хойшх үеийн үндсэн сэдэв юм. Тэр дундаа засгийн газар, УИХ-ын гишүүдийг бүр цаашилбал УИХ-ын дарга, ерөнхий сайд, ерөнхийлөгчийг хүртэл эмээлгүй давстай шорвог үгээр даваадуулан ёгтолдог, шоглодог, хорноор даапаалдаг болж ирлээ. Өөрөөр хэлбэл ерээд оноос өмнө байсан сумын даргаас дээш албан тушаалтныг шоглодоггүй явдал нэгэнт алга болов. Харин ч аль болох томоохон албан тушаалтай улс төрчийг нүүр хийх газаргүй болтол нь амыг нь асуун хорноор ёгтлох

«

*1970, 1980-аад оны үед
хариуцлагагүй дарга, хүн чанараа
алдагсад, төлөвлөгөө таслалт,
хуурамч хяналт шалгалт,
хөрөнгөтний нийгмийн
тогтолцоо, хоосон цэцэрхэгчид,
хүнд суртал гэх мэт сэдвээр
бичигдсэн нийтлэл давамгайлж
байв.*

»

боллоо. Энэ бол хошин шог нийтлэл нийгмийн гэм дутагдлыг эмчлэх үүргээ гүйцэтгэж байгаа чухал үзэгдэл мөнөөсөө мөн. Ялангуяа дараах сэдвүүдээр бичигдсэн нийтлэл цаг үеийн шинжтэй болжээ. Учир нь бидний үед ардчилал, хүний эрх, эрх чөлөөт байдал ирснээр авлига авах, өгөх, мөнгийг шүтэх, эх хэлнийхээ цэвэр ариун байдлыг алдагдуулах, улс төрийн тогтолцоо нь согогтой болсон гээд олон ч сөрөг зүйл дагуулсан билээ.

1990-ээд оноос хойш авлига хээл хахуулийн сэдвээр олон хошин шог нийтлэл бичих болжээ. «Тоншуул» сэтгүүлд нийтлэгдсэн Н.Даваадашийн «Найраа гэж»⁸ егөөдөл Монголд найраагүй юм үгүй болсныг дурдаад найраануудыг нэрлэн төрөлжүүлэн егөөджээ.

Хэл ярианы соёл алдагдуулагчид бол орчин үеийн хошин шог нийтлэлийн нэг онцгой сэдэв мөн. Эдгээр нийтлэлүүд нь хэл ярианы соёл, цэвэр ариун эх хэлний маань эвдрэлд санаа зовон эмзэглэснээрээ сайшаалтай юм. Цэвэр ариун монгол эх хэлээ бид ариунаар нь авч үлдэхгүй бол хэн авч үлдэх вэ? гэдэг санаа хүчтэй тусч байна. Шинэ нийгэм, шинэ цаг үе, шинэ хөгжил, шинэ иргэншил, шинэ амьдралын хэв маяг нийгэмд бий болсноор бидний үгийн санд шинэ шинэ үг хэллэг орж ирж монголчууд бид хэтэрхий интернациональчлагдаж глобалчлагдан «Сайн байна уу?», «Сайн уу?», «Сонин юу байна», «Өглөөний мэнд» гэх мэндчилгээнийхээ үгийг хүртэл голж шилэн гадуурхаж «Hello», «Hi», «Good morning» гэх мэт харь үгээр солин гангарах болсон билээ. Тэгж л их англиар ярих сонирхолдоо хөтлөгдөөд

байгаа юм бол, ерөөсөө англиар ярьдаг, монголоор ганц үг ч хэлдэггүй болох хэрэгтэй шүү дээ хэмээх санааг хошин шогчид донжтой ёгтолсон нь олзуурхуштай.

Улс төрийн тогтолцооны согог шинэ үеийн хошин шог нийтлэлийн үндсэн сэдвийн нэг болжээ. Ялангуяа УИХ, УИХ-ын гишүүд, улс төрийн амьдрал хошин шог нийтлэлийн байнгын бай болох болсон байна. «Тоншуул» сэтгүүлд нийтлэгдсэн Н.Даваадашийн «УИХ-д лав өө байхгүй»⁹ егөөдөл, Шаг.Цэнд-Аюушийн «Эрхэм гишүүний эрэл»¹⁰ шог өгүүллэг, Д.Жаргалсайханы «Улс төрийн реалити шоу»¹¹, «Улс төрийн сонгомол яруу найраг»¹², А.Амарсайханы «Хөдөлгөөн»¹³ шог өгүүллэг, Э.Саран-Өлзийн «Их хурал дахь эрээвэр хураавар явдлууд»¹⁴ гэсэн улс төрчдийг шоглосон шар мэдээ, Н.Даваадашийн «Янхантай улс төрийн шинэ лекц»¹⁵ шог найруулал, «Цоохор хөргийн хэлхээс»¹⁶ хөргийн эвлүүлэг, Ц.Доржготовын «УИХ-ын чуулганы ил ба далд уур амьсгал»¹⁷ шог найруулал гэх мэт тоо томшгүй хошин шог нийтлэл улс төрийн сэдвээр бичигджээ. Н.Даваадашийн «УИХ-д лав өө байхгүй» егөөдөл энэ сэдвээр бичигдсэн нийтлэлүүдээс дэвшүүлсэн санаа, бичигдсэн арга барилаараа онцлог нэг нь юм.

Хошин шог сэдвээр 1990 оноос хойш бичиж байсан сэтгүүлчдийн гол төлөөлөл бол Н.Иштавхай, Н.Даваадаш, Ц.Доржготов, И.Цэрэнжамц, Д.Баясгалан, Г.Жамьяандорж, Л.Ожгоош, Г.Рачаа, Ж.Барамсай, Н.Пүрэвсүрэн, М.Гүрсэд, Б.Ханд, А.Амарсайхан, Ц.Ганбаатар, Шаг.Цэнд-Аюуш, Д.Жаргалсайхан, Б.Батчимэг, С.Баярхүү, З.Ганболд,

Ж.Отгонцагаан, Ц.Нацагдорж, Ш.Бадам-ханд, Ю.Санжаагончиг, Ж.Лхагва, Б.Цэнддоо, Д.Санжжав, Я.Төмөр-Очир, Ц.Сайннямбуу, З.Ядмаа, Л.Одончимэд, М.Баасанжав, Ц.Байды, Ш.Ёолк, Г.Дамба, Д.Гармаа, С.Цогтбаяр, Ж.Гун-Аасүрэн, А.Бат-Эрдэнэ, Д.Мянганзам, О.Цэрэндаш, Г.Ховдгол, Н.Шоопор нар юм

«Матар» сэтгүүлийн үеийн харгис хэрцгий фашизм, ардын шинэ сургуулийн шинэ үсгийн урагшгүй багш, сурагчид, муу малчид, харгис этгээдүүд, бохир заваан байдлыг шоглосон нийтлэлүүд «Хүмүүжил жигшил» сэтгүүлийн үеэс үзэгдэхээ больсон нь хошин шог нийтлэл цаг үеийн үзэгдэл байдгийг давхар харуулж байна. «Тоншуул» сэтгүүлийн үед ч өөр шинэ шинэ үзэгдэл хошин шог нийтлэлийн үндсэн сэдэв болсон байх жишээтэй. 1990 оноос хойшх үеийн «Тоншуул» сэтгүүлд албан ажил цалгардуулдаг, албан тушаалтан, архичид, завхай явдалтан, гэр бүлийн хүчирхийлэгчид, хүн чанараа алдагсад, баяр цэнгэл хөөгчид болон элдэв олон баяр цэнгэл, байгаль эхээ сүйтгэгчид, ардчилал, шударга ёс, хүний эрх зөрчигчид, улс төрийн тогтолцооны согог, авлига авагчид, цэнгээний газрууд, хэл ярианы соёл алдагдуулагчид, зурхайчид, мөнгөнд дулдуйдагчид, боловсролын тогтолцоо, хов жив хөөцөлдөгчид, цагдаа нарыг шоглосон нийтлэл олноор нийтлэгдэх болжээ. Харин эдгээр сэдвээр бичигдсэн хошин шог нийтлэл «Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлд бараг байгаагүй байна. Ер нь ганц хоёр сэдэв л Монголын хошин шог нийтлэлийн аль ч үеийн хэвлэлд тус ч иржээ. Албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй

албан тушаалтныг шоглосон нийтлэл аль ч үеийн Монголын хошин шог хэвлэлд хэвлэгдэж ирсэн байна.

1990 оноос хойшх үеийн «Тоншуул» сэтгүүлд албан ажил цалгардуулдаг албан тушаалтан, архичид, баяр цэнгэл хөөгчид болон олон баяр цэнгэл, ардчилал, шударга ёс, хүний эрх зөрчигчид, улс төрийн тогтолцооны согог, авлига авагчид, зурхайчдыг шоглосон нийтлэл түлхүү нийтлэгдэх болсон байна. Гэхдээ орчин үеийн хошин шог нийтлэлд завшигчид, залилан мэхлэгчид, луйварчид, бохир заваан байдал, тамхичид, залхуучууд, хариуцлагагүй эмч нар, завхай явдалтан, хоосон цэцэрхэгчид, мөнгөнд дулдуйдагчид, хов жив хөөцөлдөгчид, боловсролын тогтолцоо, байгаль эхээ сүйтгэгчид, хэл ярианы соёл алдагдуулагчид, цэнгээний газруудыг шоглосон нийтлэл харьцангуй цөөхөн байгаа нь үнэнхүү анхаарал татах бөгөөд учир дутагдалтай. Учир нь хүмүүний ёс суртахууны тулгуур ойлголтыг ганхуулсан эдгээр зөрчил дутагдал бол бидний санааг зовоож байгаа гол зүйл төдийгүй хамгийн ихээр шог хошин нийтлэлд өртөх учиртай юм.

Ишлэл

- ¹ «Матар». 1943, №1.
- ² «Матар. 1943, №6.
- ³ «Хүмүүжил жигшил». 1964, №9.
- ⁴ «Хүмүүжил жигшил». 1963, №1-2.
- ⁵ «Хүмүүжил жигшил». 1962, №2.
- ⁶ «Хүмүүжил жигшил». 1962, №1.
- ⁷ «Хүмүүжил жигшил». 1961, №3-4.
- ⁸ «Тоншуул». 2002, №11, 12.
- ⁹ «Тоншуул». 2002, №15.
- ¹⁰ «Тоншуул». 2006, №05.
- ¹¹ «Тоншуул». 2002, №16, 17.
- ¹² «Тоншуул». 2002, №16, 17.

- ¹³ «Тоншуул». 2006, №02.
- ¹⁴ «Тоншуул». 2004, №16.
- ¹⁵ «Тоншуул». 2006, №11.
- ¹⁶ «Тоншуул». 2006, №01.
- ¹⁷ «Тоншуул». 2002, №10.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Даржаа Д.* 1951. Шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийн нэн хурц хэлбэр бол инээдэмт шог зохиол, шог зураг. «Үнэн» сонин. №60.

2. *Даржаа Д.* 1969. Шог хошин зохиол. «Утга зохиол урлаг» сонин. №37.

3. *Бааст Б.* 1964. Өөлөх үү? Шоолох уу? «Урлаг утга зохиол» сонин. №50.

4. *Ванган Л.* 1967. Шог зохиолын дайчин чанар. «Үнэн» сонин. №25.

5. *Гаадамба Ш.* 1964. Шогловол хаширтал, шилбүүрдвэл хорстол. «Урлаг утга зохиол» сонин. №30.

6. *Гаадамба Ш.* 1967. Шог найруулал бичих тухай. «Үнэн» сонин. №25.

7. *Лувсанвандан С.* 1973. Шог зохиолын учир. «Монголын орчин үеийн уран зохиолын онол түүхийн асуудалд». УБ.

8. *Лувсанвандан С.* 1964. Шог зохиолыг элбэгжүүлье. «Соёл, утга зохиол» сонин. №29.

9. *Содов Л.* 1965. Шог зохиол, шог найрууллын тухай. «Утга зохиол урлаг» сонин. №10.

10. *Жигмэдготов О.* 1969. Шог найруулал. «Хөдөлмөр» сонин. №76.

11. *Сэнгээ Д.* 1955. Шог найрууллын тухай. Ховд аймгийн «Хөдөлмөр» сонин. №34.

12. *Цэенжав Н.* 1965. Шог хошин зохиолыг анхаарах цаг болжээ. «Утга зохиол урлаг» сонин. №10.

13. *Хасбаатар Ц.* 1989. Шог хошин зохиолын тухай. «Уран зохиолын тухай тэмдэглэл». УБ.

14. *Өлзийбаяр Д.* 1988. Монголын орчин үеийн шог хошин зохиолын төрөл зүйлийн тухай. «Цог» сэтгүүл. №5.

15. *Цэнд-Аюуш Ши.* 1988. Далаад оны инээдмийн зохиол. «Уран зохиолын шүүмжлэлийн тухайд». УБ.

16. *Нарантуяа Р.* 1995. Далан худалчийн үлгэр нийгэм улс төрийн шог хошин өнгө аясыг олсон нь. «Аман зохиол судлал». УБ.

17. *Норовсүрэн Л.* 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

18. *Норовсүрэн Л.* 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

Резюме

Настоящая статья посвящена тематике сатирико-юмористической периодической печати Монголии, начиная с 1940-х гг. Эмпирической базой исследования послужили такие газеты и журналы, как «Матар» («Крокодил»), «Хүмүүжил жигшил» («Воспитание и презрение») и «Тоншуул» («Дятел»). Смена политико-экономической формации, ориентиров ценностей, этико-моральных устоев, по мнению автора, играют решающую роль в выборе тематики сатирико-юмористических публикаций. Большие пертурбации, кроме того, претерпели объект насмешки или антигерой публикаций, отношение журналиста к нему, острота сарказма и т. п.